



АШУУИС

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

"Оюутны хөгжил" хөтөлбөрийн
ажлын хэсэг, удирдамж, төлөвлөгөө
батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дүгээр зүйл, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.1, 4.8.2, 4.8.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2023 онд хэрэгжих "Оюутны хөгжил" хөтөлбөрийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг ханган, батлагдсан хөтөлбөрийн удирдамжийн дагуу төлөвлөгөө гаргаж, холбогдох үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Оюутны хөгжил, удирдлагын газрын дарга (Д.Оюунбилэг), хөтөлбөрийн удирдамжийг идэвх санаачилгатай хэрэгжүүлж ажиллахыг бүрэлдэхүүн сургуулийн захирлууд, чиглүүлэгч багш нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалаар батлагдсан хөтөлбөрийн удирдамжийг салбар сургуулийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж ажиллахыг Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль, Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль, Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн захирал (Б.Баясгаланмөнх, Д.Гүндэгмаа, М.Отгончимэг) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Хөтөлбөрийн удирдамжийг ханган ажиллах багш нарын албан тушаалын зэрэглэлд харгалзах сургалтын ачааллын онооны 15 хувийг хөнгөлж тооцохыг

D:\2023 A Тушаал\01.doc

601020010000

Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга (С.Хандмаа)-д зөвшөөрсүгэй.

5.Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/187 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Багшийн хөгжил, цахим сургалтын газрын дарга (Г.Батбаатар)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Н.ХҮРЭЛБААТАР